# ХУДАЛДАН АВАЛТ, ГЭРЭЭЛЭЛТИЙН ГАЗРЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025.05.27

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Тэрбум, төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэ-лийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилго 1.** Даатгуулагчийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн цахим тогтолцоог бэхжүүлнэ. | | | | | | | |
| Зорилт 1.2. Цахим шилжилтэд бүрэн шилжинэ. | | | | | | | |
| 1.2.7 | *МУТЖҮЧ-2.2.5, ЗГҮАХ-2.1.7* Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын гэрээ, гэрээний мэдээллийг бүртгэж, цахим мэдээллийн нэгдсэн сан үүсгэнэ. | - | Цахим системд бүртгэсэн ЭМБ-ын тоо | -Selection.1818.mn программаар сонгон шалгаруулалт, гэрээлэлтийн дата мэдээлэл бүрдүүлсэн.<br><br>-Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгагдсан 34 лавлагаа шатлал, 52 анхан шатлал, 150 эмийн сангийн мэдээлэл, Магадлан итгэмжлэлийн хугацаа сунгагдсан 71 эмнэлгийн мэдээллийг цахим системд бүртгүүлсэн. | Сонгон шалгаруулалт, гэрээлэлтийн цогц системийн шинээр боловсруулж, датаг зөөврөлж, үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байна. | Сонгон шалгаруулалт, гэрээлэлтийн цахим програм www.selection.1818.mn-д 2025 онд дараах хөгжүүлэлтүүдийг хийлгэж, бүртгэл мэдээллүүдийг шинэчилж ажиллаа.<br>Үүнд:<br>- 2025 онд шинээр байгуулагдсан 2, эмнэлгийн төрөл нь өөрчлөгдсөн 1, нийт 3 анхан шатны эрүүл мэндийн байгууллагад тус програмд нэвтрэх эрхийг олгож, холбогдох мэдээллийг бүртгүүллээ.<br>-Гэрээлэлт –Анхан шат цэсэнд 2025 он гэсэн цэсийг шинээр үүсгүүлэн 2025 онд гэрээ байгуулсан 555 анхан шатны эрүүл мэндийн байгууллагын нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн 20 хувийг олгоход шаардагдах гэрээ гүйцэтгэлийг үнэлэх 7 шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшинг сар бүрээр нь оруулах талбарыг үүсгүүлж 555 анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудаас шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшний саналыг авч, хүрэх түвшинг сар бүрээр нь тооцоолон гаргаж сонгон шалгаруулалт, гэрээлэлтийн систем оруулсан.<br>-2025 онд зохион байгуулах сонгон шалгаруулалтын мэдээлллийг баазыг бүрдүүлэх болон 2025 оны гэрээлэлтийг хийх | 90% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Тэрбум, төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэ-лийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажлын хүрээнд сонгон шалгаруулалт, гэрээлэлтийн цахим програм www.selection.1818.mn-д "Нөөцийн мэдээлэл" цэсийг үүсгүүлэн гэрээт анхан шатны 555 эрүүл мэндийн байгууллага, лавлагаа шатлалын 321 эрүүл мэндийн байгууллагын хүний нөөц, тоног төхөөрөмж, тусгай нэгж байгууламжийн мэдээллийг тус програмд шинэчлүүлэх тухай зарыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын цахим хуудаст 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдөр байршуулж, мөн лавлагаа шатлалын Эрүүл мэндийн байгууллага бүрт 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 05/4367 дугаартай, 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 05/225 дугаартай албан бичгүүдийг тус тус хүргүүлж, нөөцийн мэдээллүүдийг шинэчлүүлсэн. Тус мэдээллийн баазыг бүрдүүлснээр эрүүл мэндийн байгууллагуудын тусгай зөвшөөрөл дэх үйл ажиллагааны чиглэл, бүс нутгийн байршил, хүний нөөц, тоног төхөөрөмж, орны тоо зэргийг харгалзан сонгон шалгаруулалтыг үнэн зөв бодитой хуулийн хүрээнд ил тод зохион байгуулах нөхцөл бүрдэх юм. Одоогоор сонгон шалгаруулалт, гэрээлэлтийн цахим програм www.selection.1818.mn-д "Нөөцийн судалгаа" цэсэнд 876 эрүүл мэндийн байгууллагуудын нөөцийн мэдээллийг шинэчлэн бүртгүүлсэн байна.<br>Сонгон шалгаруулалт, гэрээлэлтийн цахим програм www.selection.1818.mn-ийг цаашид | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Тэрбум, төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэ-лийн хувь |
| --- | --- | --- | --- | --- | --- | --- | --- |
| | | | | | | үргэлжлүүлэн нэгдсэн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, эсвэл тус програм дахь дата бааз мэдээллийг хүлээн авч өөр програмыг шинээр хийх талаар зөвшилцөх уулзалтуудыг холбогдох хэлтэс болон зөвлөхүүд, програмын админтай зохион байгуулж байна. | |
| | | | | | Гэрээт эрүүл мэндийн байгууллагын гэрээ байгуулсан тусламж, үйлчилгээний төрөл, хаяг байршлын мэдээллийг Олон нийтэд мэдээллэх, сурталчилах зорилгоор байгууллагын цахим хуудаст байршуулна. | - Гэрээт Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын гэрээлсэн тусламж, үйлчилгээг төрөл тус бүрээр нь, хэвтүүлэн эмчлэх эмийн, мэсийн тусламж, үйлчилгээг ОУ-ын ICD-10 ангилаар ангилан, байгууллагын нэр, хаяг байршилтай нь ОНХХ-т 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 07/850 дугаартай дотоод албан бичгээр хүргүүлж, ЭМДЕГ-ийн цахим хуудасны Мэдээ, мэдээлэл хэсэгт байргуулсан. Мөн Байгууллагын пейж хуудасны "Гэрээт эрүүл мэндийн байгууллага" цэсэнд хөгжүүлэлт хийх зураглалыг ОНХХ-т танилцуулсан.<br>Анхан шатны Эрүүл мэндийн байгууллага тус бүрийн нэг иргэн, ЭМДТ хуулийн 9.1.9-д заасан гэрээт тусламж, үйлчилгээний төрөл, сум тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх ОХБ-ийг нэгтгэн гаргаж, МТХ-т 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 07/275, 2025 оны 02 дугаар сарын 07/318 дугаартай дотоод албан бичгүүдээр Бодлогын даалгавар, дата мэдээллийг хүргүүлж, цахим системд шинэчлэн тохиргоог хийлгүүлсэн.<br>Эрүүл мэндийн сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг нь "Эрт ирүүлэг | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Тэрбум, төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэ-лийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2,0 хөтөлбөр"-ийн хүрээнд эрт илрүүлэгт хамрагдсан иргэдийн мэдээллийг цахим системд бүртгэлжүүлж, Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн санг үүсгэж буйтай холбоотой 300 эрүүл мэндийн байгууллагын ID бүртгэлийг тулгаж, 590 бүртгэлийг нэгтгэж, МТХ-т хүргүүлж ажилласан. | |
| | | | | | Гэрээт эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэл, тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацааны өөрчлөлтийн мэдээллийг тухай бүрт нь цахим системд хийлгэнэ. | Магадлан итгэмжлэлийн хугацаа сунгагдсан анхан шатны 81 байгууллага, лавлагаа шатлалын 50, **нийт 131** байгууллагын мэдээлэл, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгагдсан 53 анхан шатны, 168 эмийн сан, лавлагаа шаталалын 2, **нийт 223** эрүүл мэндийн байгууллагын мэдээллийг МТХ-ийн хэлтэст ДАБ хүргүүлж, цахим системийн тохиргоог хийлгүүлсэн. | |
| Зорилт 1.3.Салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгоно. | | | | | | | |
| 1.3.1 | *БСТ- 2.1.3*<br>Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийг шинэчлэн найруулах ажлын хэсэгт санал хүргүүлнэ. | - | Хүргүүлсэн саналын тоо | ЭМДҮЗ-ийн 3 тогтоол, 1 тушаалд санал өгч боловсруулан батлагдсан. | Холбогдох хуулийн төслүүдэд санал боловсруулж, ажлын хэсэгт санал хүргүүлсэн байна. | "Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогыг бүрдүүлэх, цуглуулах, төвлөрүүлэх журам"-ын төсөлд 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдөр 11 заалтаар санал хүргүүлсэн. | 100% |
| 1.3.3 | *ЭМДТХ-10.1, "Алсын хараа 2050" МУУХХБ-2.2.12* | - | Шинэчлэгдэн батлагдсан журам | ЭМДЕГ-ын даргын 2022 оны А/61, 2023 оны А/01 дүгээр тушаал хэрэгжсэн. | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээний | Хугацаа болоогүй | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Тэрбум, төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэ-лийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | "Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ худалдан авах гэрээний хэрэгжилтийг үнэлэх, дүгнэх нийтлэг журам"-ыг шинэчлэн баталж, мөрдүүлнэ. | | | | хэрэгжилтийг үнэлэх, дүгнэх нийтлэг журмыг шинэчлэн батлуулна. | | |
| | | | | | Шинэчилсэн журмын дагуу 2025 оны гэрээний хэрэгжилтийг үнэлж, үр дүнг тооцсон байна. | Хугацаа болоогүй | |
| 1.3.4 | "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээний үлгэрчилсэн загварыг шинэчлэн батлах тухай" ЭМДҮЗ-ийн тогтоолыг шинэчлэн батлуулж, мөрдөнө. | - | Шинэчлэн батлагдсан тогтоол | Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 13 дугаар тогтоол хэрэгжсэн. | Шинэчлэн батлагдсан тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж ажилласан байна. | Хугацаа болоогүй<br><br>***Бэлтгэл ажлын хүрээнд:***<br>Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээнд өөрчлөлт оруулахаар Худалдан авалт, гэрээлэлтийн газраас Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйл 62.1-т заасныар Захиргааны хэм хэмжээний актын төсөлд холбогдох газар, хэлтэс болон олон нийтэд Эрүүл мэндийн даатгалын цахим хуудсанд байршуулан 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдрөөс 2024 оны 08 дугаар сарын 04-ний өдрийг хүртэл хугацаанд Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар 40, Эрүүл мэндийн байгууллага, холбоодоос 89, Монгол улсын Эрүүл мэндийн яам 2, Монгол улсын Сангийн яам 5, нийт 136 санал ирж нэгтгэгдсэн. ХАГГ-ын зөвлөхтэй хамтран шалгуур үзүүлэлт боловсруулах ажил хийгдэж байна. 2025 оны | 80% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Тэрбум, төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэ-лийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 06 дугаар сард ЭМДҮЗ-ийн хурлаар хэлэлцүүлэхээр төлөвлөсөн. | |
| Зорилт 1.4.Хөндлөнгийн хяналтад тулгуурласан хамтын ажиллагааг бэхжүүлнэ. | | | | | | | |
| 1.4.1 | *БСТ-1.4.1* Иргэн даатгуулагчийн хөндлөнгийн хяналтыг бий болгоно. | - | - Мессэжээр мэдээлэл илгээсэн иргэдийн тоо - Илэрсэн зөрчлийн тоо | Иргэд, даатгуулагчдад авсан тусламж, үйлчилгээний талаарх мэдээллийг 1904 иргэнд мессежээр хүргэсэн. 37 ЭМБ-д хяналт хийж, гаднаас эм тариа, эмнэлгийн хэрэгсэл авхуулсан 10 иргэний төлбөрийг буцаан олгуулах арга хэмжээ авсан. | Даатгуулагчийн хөндлөнгийн хяналтын тогтолцоо бий болсон байна. | Одоогоор мессеж үйлчилгээний үр дүнг МТХ-ээс мэдээллээгүй байгаа бөгөөд газар дээрх хяналт хийгдээгүй байна.<br><br>Харин иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын мөрөөр ажиллаж, 4 иргэнд нийт 5,214,650,000 төгрөгийн буцаан олголтыг холбогдох эрүүл мэндийн байгууллагаар олгуулж, гомдлыг барагдуулсан. Мөн иргэн Г.Амардэлгэрийн 11-11-т гаргасан гомдлын мөрөөр Нийслэлийн Мандалфарм эмийн санд газар дээрх хяналт хийж, хяналт шалгалтын үр дүнг иргэнд мэдэгдсэн. Хэрэгжих хугацаа бүрэн дуусаагүй. | 50% |
| 1.4.3 | Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, Төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, холбогдох байгууллагатай | - | - Сургалт, арга зүйгээр хангасан тохиолдлын тоо - Шийдвэрлэсэн гомдол | 2024 онд 117 гомдол, мэдээллийг бүртгүүлж, 20 удаагийн торгох шийтгэл оногдуулсан. | Ирүүлсэн гомдол мэдээллийг хуулийн хүрээнд шийдвэрлэсэн байна. | Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах төв 11-11-ээр 47, 1800-13-63 дугаарын утсаар 9, Абле системээр 26, нийт 82 өргөдөл, гомдол ирсэн бөгөөд шийдвэрлэлт 79.8%-тай байна. | 100% |
| | | | | | Ирсэн гомдол, мэдээллийг улирал бүр нэгтгэн, дүн шинжилгээ хийнэ. | ХАГГ-т Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах төв 11-11, ЭМДЕГ-ын 1800-13-63 дугаарын утсаар, Абле системээр ирсэн нийт 82 өргөдөл, гомдолд дүн шинжилгээ хийж ажилласан. | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Тэрбум, төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэ-лийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хамтран ажиллана. | | мэдээллийн тоо | | | | |
| **Зорилго 3:** Тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, худалдан авах үйл ажиллагааг хялбарчилна. | | | | | | | |
| Зорилт 3.1.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн чанарт үндэслэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авч, чанарын хяналтыг сайжруулна. | | | | | | | |
| 3.1.1 | Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ болон даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх гэрээ байгуулах үйл ажиллагааг зохион байгуулна. | - | Байгуулсан гэрээний тоо | 552 ӨСЭМТ, 1514 эмийн сан, гэрээ байгуулан ажилласан. | - 2024 оны гэрээний хэрэгжилт хангалттай үнэлэгдэж, гэрээ үргэлжлүүлэн байгуулах эрүүл мэндийн байгууллагуудын нэрсийг даргын тушаалаар албажуулна. | 2024 оны Гэрээний хэрэгжилт хангалттай үнэлэгдсэн 552 анхан шатны эрүүл мэндийн байгууллага, гэрээ үргэлжлүүлэх 1386, түдгэлзүүлэх 53, цуцлах 75 эмийн сангийн жагсаалтыг ЭМДЕГ-ын даргын 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/02 дугаар тушаалаар албажуулсан. | 100% |
| | | | | | Гэрээний хэрэгжилт хангалттай үнэлэгдсэн АШЭМБ, эмийн сангийн гэрээ байгуулж ажилласан байна.<br>-Шинээр гэрээ байгуулах хүсэлт ирүүлсэн эмийн сангуудтай гэрээ байгуулсан байна. | 1. Гэрээний хэрэгжилт хангалттай үнэлэгдсэн 552, шинээр хүсэлт ирүүлсэн 3, нийт 555 анхан шатны эрүүл мэндийн байгууллагатай гэрээ байгуулсан байна. Үүнд:<br>-"Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 05, 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээний нэгж тохиолдлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх журмын дагуу 2025 оны батлагдсан төсвийн | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Тэрбум, төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэ-лийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүрээнд 555 анхан шатны эрүүл мэндийн байгууллага тус бүртэй хэлэлцээр хийж, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1.9 –д заасан тусламжаар 48,324,873,100 төгрөгт, Сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тусламж, үйлчилгээний хүрээнд 63,024,698,963 төгрөгт гэрээ байгуулан ажиллаа. Харин 2025 оны гэрээний хэлцлээ зөвшилцөөгүй эрүүл мэндийн байгууллагуудын мэдээллийг БТГ-т хүргүүлэн дахин тооцоолуулж, нийслэлийн 11 өрхийн эрүүл мэндийн төвтэй 754,33,750 төгрөг, Говь-Алтай аймгийн 3 сумын эрүүл мэндийн төвд 54,627,700 төгрөгийг нэмэгдүүлэн гэрээг байгуулсан.<br><br>***Цахим системийн тохируулга:***<br>-Анхан шатны эрүүл мэндийн байгууллага бүрээр гэрээний тоо, мөнгөн дүнд төсвийн сарын хуваарийг гаргуулан, байгууллагын даргаар батлуулан авч, сарын хуваарийг цахим системд тохиргоо хийлгүүлэхээр Мэдээлллийн технологийн хэлтэст 2025 оны 03 дугаар сарын 04/427 өдрийн дотоод албан бичгээр хүргүүлсэн.<br>- Мөн ЭМДҮЗ-ийн 2025 оны 04 дүгээр тогтоолын хэрэгжилттэй холбоотой сум тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх архаг, төлөвлөгөөт, цочмог тусламж, үйлчилгээний төсвийн хуваарьлалтыг Бодлого төлөвлөлтийн газартай хамтран эрүүл мэндийн даатгалын цахим програмд 2025 оны 03 дугаар сараас 2025 оны 12 | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Тэрбум, төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэ-лийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дугаар сарыг дуустал хугацаанд тохируулсан.<br>- Тус тохируулгатай холбоотой архаг тусламж, үйлчилгээний төсвийг нэмэгдүүлэх, төлөвлөгөөт тусламж, үйлчилгээний төсвийг бусад тусламж руу шилжүүлэх зэрэг эрүүл мэндийн байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийг судалж, 328 сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдээс архаг, төлөвлөгөөт, цочмог үеийн тусламж, үйлчилгээний төсвийн сарын хуваарийн саналыг дахин авч, нэгтгэн эмнэлгийн тусламж, үйлчилгээний төсвийн сарын хуваарийг 2025 оны 04 дүгээр сараас хойш цахим системд дахин тохируулсан.<br>-ЭМДҮЗ-ийн 2021 оны 13 дугаар тогтоол, 2025 оны 03 дугаар тогтоолуудын хүрээнд 555 анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын 2025 оны гэрээний шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшнийг Selection1818.mn цахим системд оруулуулж, гэрээний иж бүрдлийг хангаж ажилласан.<br><br>**Шинээр байгуулсан гэрээний тухайд-3:**<br><br>- Нутаг дэвсгэрийн зохион байгуулалтад орж, шинээр гэрээ байгуулахаар хүсэлт ирүүлсэн Баянгол дүүргийн Сан Эго Фамили ӨЭМТ-тэй УБ-05/553, Хан-Уул дүүргийн Энхтүмэн өрх ӨЭМТ-тэй УБ-05/554, Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээнээс анхан шатны тусламж, үйлчилгээрүү шилжсэн Багахангай дүүргийн Эрүүл мэндийн төвтэй | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Тэрбум, төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэ-лийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах УБ-01/001 дугаартай гэрээг цуцалж, Анхан шатны тусламж, үйлчилгээ худалдан авах 05/0555 дугаартай гэрээг шинээр байгуулсан.<br><br>**Нэмэлт гэрээний тухайд-4**<br>Хаяг байршил, эрх бүхий албан тушаалтны мэдээлэл өөрчлөгдсөн **2**, Тсуламж, үйлчилгээний төрөл нэмүүлсэн **2**, нийт **4** анхан шатны эрүүл мэдийн төвтэй нэмэлт гэрээ байгуулж, шилэн дансанд байршуулсан. Үүнд:<br>- Орхон сумын эрүүл мэндийн төвийн дарга өөрчлөгдсөн тул ДА-05/0108-003 дугаартай нэмэлт гэрээг.<br>- Дундговь аймгийн Боржигон мандал ӨЭМТ засаг даргын захирамжаар татан буугдаж, Өлзийтмандал ӨЭМТ-тэй нэгтгэгдэн тус төвийн нэг иргэний тоо, төсөв нэмэгдсэн тул ДУ-05/165-004 дугаартай нэмэлт гэрээ байгуулсан<br>- Газар дээрх хяналтын үр дүнг үндэслэн ЭМД-ын тухай хуулийн 9.1.9-д заасан тусламж, үйлчилгээгээр Нийслэлийн Номгонжаргалант ӨМТ, УСЭИҮОШ-ний 18-30 насны багц тусламж, үйлчилгээгээр Өрнөх Эрүүл жаргал ӨЭМТ-тэй нэмэлт гэрээ байгуулсан. | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Тэрбум, төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэ-лийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2.Гэрээний хэрэгжилт хангалттай үнэлэгдсэн 1417, шинээр хүсэлт ирүүлсэн 92, нийт 1509 эмийн сантай үндсэн гэрээ байгуулсан-**1509**. Үүнд:<br><br>Эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах 2024 оны гэрээний үр дүнг хангалалттай үнэлүүлж, гэрээ үргэлжлүүлэн байгуулахаар шийдвэрлэсэн **1385** эмийн сангаас гэрээ байгуулахгүй гэж мэдэгдсэн Нийслэлийн 7, Орон нутгийн 3, нийт 10 эмийн сан байсан ба хүсэлтийн дагуу гэрээг үргэлжлүүлэн байгуулаагүй. Харин бусад 1375 эмийн сан болон Улсын байцаагчийн албан шаардлагын биелэлтийн хариуг ирүүлсэн 42 эмийн сан, нийт 1417 эмийн сантай 2025 оны гэрээг үргэлжлүүэн байгуулсан.<br>Шинээр хүсэлт ирүүлсэн 92 эмийн сантай Даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах гэрээг байгуулан, цахим системийн тохиргоог тухай бүрт нь МТХ-т дотоод албан бичгээр хүргүүлж ажиллаа.<br><br>**3.Нэмэлт гэрээний тухайд-8:**<br>Хаяг байршил, эрх бүхий албан тушаалтны мэдээлэл өөрчлөгдсөн 8 эмийн сантай нэмэлт гэрээ байгуулж, шилэн дансанд байршуулан, холбогдох цахим системийн тохиргоог МТХ-т дотоод албан бичиг хүргүүлж, шийдвэрлэсэн. Үүнд: | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Тэрбум, төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | | | | Гүйцэтгэл-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **Гэрээний дугаар** | **Аж ахуйн нэгжийн нэр** | **Эмийн сангийн нэр** | **Шалтгаан** | |
| | | | | | | УБ-04/0030-001 | Тавин ус ХХК | Тавин ус эмийн сан 7 | Хаяг байршил өөрчлөгдсөн | |
| | | | | | | ДА-04/0825-002 | ЭХНБ ХХК | Дархан-Уул | ХХК-ийн эзэмшигч өөрчлөгдсөн. | |
| | | | | | | УБ-04/0244-003 | Цахиур төмөр агар ХХК | Агар фарм-100 | Хаяг байршил өөрчлөгдсөн | |
| | | | | | | УБ-04/0182-004 | Монгол фарм ХХК | Монгол фарм Нарны хороолол | Хая, оноосон нэр өөрчлөгдсөн | |
| | | | | | | УБ-04/0367-005 | Монос Улаанбаатар ХХК | Монос Хоумплаза | Эрхлэгч солигдсон | |
| | | | | | | БХ-04/0721-006 | Өлзийт наян булаг ХХК | Наян булаг ганга | ХХК-ийн нэр өөрчлөгдсөн | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Тэрбум, төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэ-лийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулах ажлын төлөвлөгөө, хуваарийг боловсруулан, нэгжийн даргаар батлуулна | Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулах бэлтгэл ажлын хүрээнд 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр гэрээ байгуулах ажлын төлөвлөгөөг боловсруулж, нэгжийн даргаар батлуулж, батлагдсан хуваарийн дагуу холбогдох мэргэжилтнүүд гэрээ байгуулан ажиллаа.<br>Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулах хэлцэл хийх үед шаардлагатай мэдээллээр хангах үүднээс Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын тусгай зөвшөөрөл, үйл ажилалааны чиглэл, хүчин чадлын судалгааг гаргасан.<br>Мөн ХАГГ-ын мэргэжилтнүүдийн ачааллыг тэнцвэржүүлэх үүднээс Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага бүрийн тусламж, үйлчилгээний төрлийн судалгааг гарган, хуваарилж, нэгжийн даргаар 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр батлуулсан. | |
| | | | | | Нэмэлт гэрээ байгуулах гэрээний загварыг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна. | ЭМДҮЗ-ийн 2025 оны 04 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эрүүл мэндийн байгууллагуудтай 2022 онд байгуулсан “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ”-нд нэмэлт гэрээний төслийг Эрүүл мэндийн даатгалын тухай хууль болон бусад хууль тогтоомж, ЭМДҮЗ-ийн тогтоолд нийцүүлэн боловсруулсан. | |
| | | | | | Гэрээний талуудтай зөвшилцөх | **Гэрээний талуудтай зөвшилцөх хэлцэл хийх бэлтгэл ажлын хүрээнд-321**: | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Тэрбум, төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэ-лийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.2 | Батлагдсан төсвийн хүрээнд гэрээт эрүүл мэндийн байгууллагуудтай хэлцэл хийж, хүний нөөцийн чадавхи, хүчин чадлыг харгалзан үзүүлэх тусламж үйлчилгээний тоо хэмжээг оношийн хамааралтай бүлэг бүрээр тохирч гэрээнд тусгана. | - | Хэлцэл хийсэн ЭМБ-ын тоо | -Лавлагаа шатлалын 289 эрүүл мэндийн байгууллагатай хэлцэл хийсэн.<br><br>- Гэрээт 7 эрүүл мэндийн байгууллагын хүсэлтээр талууд хэлцэл хийн хугацаанаас өмнө гэрээг дуусгавар болгон цуцалсан. | Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлэгч Эрүүл мэндийн байгууллагуудын 2024 оны гэрээний хэрэгжилтийн үр дүнг даргын тушаалаар албажуулна. | 2024 оны Гэрээний хэрэгжилт хангалттай үнэлэгдсэн 299 лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын жагсаалтыг ЭМДЕГ-ын даргын 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/02 дугаар тушаалаар албажуулсан. | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Тэрбум, төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэ-лийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэлцлийг хийсэн байна. | - Даргын зөвлөлийн 2025 оны хуралд шинээр 2024 онд зохион байгуулагдсан Нэгдсэн сонгон шалгаруулалтад тэнцсэн 23 лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага, сонгон шалгаруулатын үр дүнд гомдол гаргасан 2 эрүүл мэндийн байгууллагын асуудлыг танилцуулж, 23 эрүүл мэндийн байгууллагатай гэрээг шинээр байгуулах, дахин үнэлгээгээр тэнцсэн 2 эрүүл мэндийн байгууллагын сонгон шалгаруулалтын үр дүнг ЭМДЕГ-ын даргын тушаалаар баталгаажуулах шийдвэр гарсны дагуу ЭМДЕГ-ын даргын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/13 дугаар тушаалаар тус 2 байгууллагын сонгон шалгаруулалтын үр дүнг баталгаажуулсан.<br>- Даргын зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 29-ний хурлаар шинэ сонгон шалгаруулалтад тэнцсэн 23 эрүүл мэндийн байгууллагатай гэрээ байгуулах төсвийн тооцооллыг танилцуулж, шийдвэрлүүлэв.<br>- Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай 2025 онд гэрээ үргэлжлүүлэн байгуулах 298, шинээр гэрээ байгуулах 23, нийт 321 эрүүл мэндийн байгууллагын хүний нөөц, тоног төхөөрөмж, тусгай нэгж байгууламжийн мэдээллийг сонгон шалгаруулалт, гэрээлэлтийн www.selection.1818.mn-д шинэчлүүлэх тухай зарыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын цахим хуудаст 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 07/1638 дугаартай дотоод албан бичиг ОНХХ-т хүргүүлж | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Тэрбум, төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэ-лийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байршуулсан. Мөн лавлагаа шатлалын Эрүүл мэндийн байгууллага бүрт 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 05/4367 дугаартай, 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 05/225 дугаартай албан бичгүүдийг тус тус хүргүүлж, мэдээллийг шийнэчлүүлсэн.<br>Тус хүчин чадлын мэдээлэл болон аймаг, нийслэлийн ор баталсан тушаалууд, тухайн эрүүл мэндийн байгууллагаас амбулаторийн кабинет, эмчийн мэдээлэл зэргийг нэмэлтээр тодруулан судалж, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны Журам батлах тухай А/56 дугаар тушаалын аргачлалын дагуу гэрээт 298, шинэ сонгон шалгаруулалтад тэнцсэн 23, нийт 321 эрүүл мэндийн байгууллагуудын хүчин чадлыг тооцоолоход 1**,284,684,083,001** төгрөг болсон. (Нийслэлийн хүүхдийн Хан туул, Бяцхан тэмүүлэл сэргээн засах төвүүдтэй гэрээлэх эсэх талаар чиглэлийг ЭМЯ-наас авч шийдвэрлэх болсон.)<br><br>**Гэрээний талуудтай зөвшилцөх хэлцэл хийх ажлын хүрээнд-321:**<br>ХАГГ-ын газрын мэргэжилтнүүд хэлэлцээр хийхэд хөтлөх хуудсыг шинэчлэн боловсруулж, лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагатай хэлэлцээр хийхэд ашигласан.<br>Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ үргэлжилж буй 298, | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Тэрбум, төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэ-лийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шинээр гэрээ байгуулах 23, нийт 321 лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагатай гэрээний хэлцэл хийсэн бөгөөд хэлцлээ зөвшөөрсөн 283 эрүүл мэндийн байгууллага, 2024 онд шинэ сонгон шалгаруулалтад тэнцсэн 17 эрүүл мэндийн байгууллага нийт 300 эрүүл мэндийн байгууллагатай 636,179,956,030.61 төгрөгийн тусламж, үйлчилгээ худалдан авахаар гэрээ байгуулж, шилэн дансанд байршуулан ажиллаа.<br><br>**Тусламж, үйлчилгээний ОХБ нэмүүлэх, хаяг байршил өөрлөгдөж хийсэн нэмэлт гэрээ-4:**<br>Лавлагаа шатлалын Найман очир ХХК--ийн Чимэг эмнэлэг нь хаяг байршил, оноосон нэрээ өөрчилж, Уромед нэртэй болсон тул УБ-02/049-0317 дугаартай нэмэлт гэрээ, СХДНЭ-т 12 ОХБ нэмж УБ-01/025-0318 дугаартай нэмэлт гэрээг, Увс аймгийн Нэгдсэн эмнэлэгтэй УВ-01/001-323, Завхан аймгийн Нэгдсэн эмнэлэгтэй ЗА-01/001- 0316 нэмэлт гэрээ байгуулав.<br>**Томуугийн түр гэрээ-3:**<br>Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахаар хүсэлт ирүүлсэн лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын хүсэлтийг судалж, нийт 2 нэмэлт гэрээг түр байгуулсан байна. Үүнд:<br>- Нийслэлийн сэргээн засах Хан туул төв нь ЭМС-ын тушаалд орж, томуугийн ор дэлгэх болсонтой холбоотойгоор | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Тэрбум, төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэ-лийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Нэмэлтээр 01/41-001 дугаартай томуугийн түр гэрээг 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд байгуулсан.<br>- Мөн Баянзүрх дүүргийн Эрүүл мэнийн төвтэй Эрүүл мэндийн сайдын Томуу, томуу төст өвчний үеийн эмнэлгийн тусламж, үйлчилгээг зохицуулах тухай 2024 оны А/435 дугаартай тушаалыг үндэслэн УБ-01/032-002 дугаартай нэмэлт гэрээг 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрөөс 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэл хугацаанд түр байгуулсан.<br>- Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн төвийн харьяа Сэлбэ эмнэлэгтэй Томуу, томуу төст өвчний үеийн 8 оношийн хамааралтай бүлгээр УБ-01/005-0319 дугаартай нэмэлт гэрээ байгуулан ажилласан. | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Тэрбум, төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэ-лийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Тусламж, үйлчилгээний тоо хэмжээг тохиролцож, гэрээнд тусган, тоо хэмжээ, мөнгөн дүнг эрүүл мэндийн даатгалын цахим системд тохиргоо хийлгэн, гэрээний үүргийн хэрэгжилтийг хангуулсан байна. | МТХ-ээс гэрээт лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдрөөс 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийг хүртлэх эрүүл мэндийн байгууллага бүрийн нэхэмжилсэн мөнгөн дүнг авч, гэрээний хэлцэлд тусган, эрүүл мэндийн байгууллага бүрт танилцуулсан.<br>Харин хэлцлээ зөвшөөрсөн 283 эрүүл мэндийн байгууллага, 2024 онд шинэ сонгон шалгаруулалтад тэнцсэн 17 эрүүл мэндийн байгууллага нийт 300 эрүүл мэндийн байгууллага тус бүрээс батлагдсан төсвийн хүрээнд 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хооронд үзүүлэх тусламж, үйлчилгээний төсвийн сарын хуваарийг удирдах албан тушаалтнаар батлуулан авсан. Нэмэлт гэрээг ЭМДҮЗ-ийн 2025 оны 04 дүгээр тогтоолын хэрэгжилттэй холбоотойгоор 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрөөс үндсэн гэрээний хугацаанд буюу 2025 оны 09 дүгээр сарын 31-ний өдрийг дуустлах хугацаанд байгуулсан.<br>Эрүүл мэндийн даатгалын цахим програмд эрүүл мэндийн байгууллага бүрийн 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрөөс 2025 оны 09 дүгээр сарын 31-ний өдрийг дуустлах хугацааны архаг, цочмог, төлөвлөгөөт тусламж, үйлчилгээний төсвийг МТХ-т 5 удаагийн дотоод албан бичгээр хүргүүлж, цахим системийн тохиргоог хийлгүүлсэн. Төсвийн сарын хуваариа өөрчлүүлэх хүсэлт | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Тэрбум, төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэ-лийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ирүүлсэн 13 эрүүл мэндийн байгууллагын хүсэлтийг үндэслэн эрүүл мэндийн даатгалын цахим програмд шинэчлүүлж, тохируулсан.<br>ЭМДҮЗ-ийн 2025 оны 04 дүгээр тогтоол шинэчлэгдэн батлагдсантай холбоотой амбулаторийн үзлэг, хяналт, эмчилгээ, оношилгоо, шинжилгээний тусламж, үйлчилгээний үзүүлж буй 221 лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын ОХБ-ийг тусгай зөвшөөрлийн чиглэлтэй уялдуулан ЭМДҮЗ-ийн 2024 оны 06 дугаар тогтоолоос хөрвүүлж, цахим системд тохиргоо хийлгүүлэхээр Мэдээллийн технологийн хэлтэст хүргүүлсэн. Мөн 298 эрүүл мэндийн байгууллагын гэрээт оношийн хамааралтай бүлгийг шинэчлэн батлагдсан тогтоолын оношийн хамааралтай бүлэг рүү хөрвүүлэн нийт 28969 оношийн хамааралтай бүлгийг эрүүл мэндийн даатгалын цахим програмд уншуулан тохиргоог хийлгэсэн. | |
| | | | | | Гэрээ цуцлах саналын хүрээнд хэлцэл хийж, гэрээг дуусгавар болгож шийдвэрлэсэн байна. | Гэрээ цуцалсан **83** эмийн сан, **1** лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага, **1** анхан шатны эрүүл мэндийн төв, нийт **85** байгууллага байв. Үүнд:<br>-Гэрээ дүгнүүлэх материал ирүүлээгүй, хангалтгүй үнэлэгдэж, ЭМДЕГ-ын даргын 2025 оны 02 дугаар тушаалаар гэрээ үргэжлүүлэн байгуулахгүй 1 лавлагаа шатлалын (Өмнөговь аймгийн Бүтэнжаргал) эмнэлэг, 75 эмийн сан, нийт 76 эрүүл мэндийн байгууллагын гэрээг цуцалж МТХ-т | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Тэрбум, төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэ-лийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дотоод албан бичиг хүргүүлж, цахим системийг хаалгуулсан.<br>- 2024 оны гэрээний хэрэгжилтээ хангалттай үнэлүүлсэн боловч гэрээ үргэлжлүүлэн байгуулахгүй гэж мэдэгдсэн Нийслэлийн 5, Орон нутаг 3, нийт 8 эмийн сангийн хүсэлтийн дагуу гэрээг үргэлжлүүлэн байгуулаагүй бөгөөд МТХ-т дотоод албан бичиг хүргүүлж, цахим системийг хаалгуулсан.<br>- Дундговь аймгийн Өлзийт мандал, Боржигон мандал ӨЭМТ-үүд аймгийн засаг даргын захирамжаар нэгтгэгдсэн бөгөөд татан буугдсан Боржигон мандал ӨЭМТ-ийн гэрээг цуцалж, цахим системийг хаан, гэрээ дуусгавар болсон тухай албан бичиг хүргүүлэв. | |
| 3.1.3 | Нэгдсэн сонгон шалгаруулалтыг зохих хууль тогтоомжийн дагуу үе шаттайгаар зохион байгуулна. | - | Тэнцсэн эрүүл мэндийн байгууллагуудын тоо (төрлөөр) | Лавлагаа шатлалын 328 эрүүл мэндийн байгууллага сонгон шалгаруулалтад тэнцсэн. | ЭМДҮЗ-ийн 06 дугаар тогтоолын шинэчлэлтийн хүрээнд Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулахад тавигдах тусгай шаардлагыг шинэчлэн боловсруулж, даргын тушаалаар батлуулах. | Хугацаа болоогүй | 50% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Тэрбум, төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэ-лийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Шинэчлэн боловсруулсан Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулахад тавигдах тусгай шаардлагын шалгуур үзүүлэлтийг Сонгон шалгаруулалтын Selection.1818.mn программд оруулах. | 2025 онд нэгдсэн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд тус сонгон шалгаруулалтад ашиглах програмын шинээр хийлгэх, эсвэл хуучин програмыг хөгжүүлэн цаашид ашиглах боломтжтой эсэх асуудлыг 2025 оны 02 дугаар сард Мэдээллийн технологийн хэлтсийн дарга болон холбогдох мэргэжилтнүүдтэй уулзаж сонгон шалгаруулалт, гэрээлэлтийн цахим програм www.selection.1818.mn-ийн бүтэц, үйл ажиллагааг танилцуулсан. Мэдээллийн технологийн хэлтсээс тус програмын хөгжүүлэлтийг хийх болон өөр шинэ програм бичих боломжгүй гэсэн мэдээллийг хэлсэн. Иймээс сонгон шалгаруулалт, гэрээлэлтийн цахим програм www.selection.1818.mn-ийг хийсэн Ай Өү ХХК-ийн захирал н.Энх-Амгалан болон холбогдох асуудал хариуцсан албан тушаалтнуудтай 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр МТХ-ийн хэлтсийн дарга Бат-Оргилтой хамт уулзан цаашид тус програмыг хэрхэх талаар санал солилцлоо. Програм хөгжүүлэгчийн зүгээс одоо ашиглаж байгаа сонгон шалгаруулалт, гэрээлэлтийн цахим програм www.selection.1818.mn-ийг цаашид хөгжүүлэх, эсвэл түүнтэй ижил төстэй сайжруулсан програм хангамж нийлүүлэхэд хэдий хэмжээний төсөв шаардлагатай талаарх үнийн саналаа ирүүлэхээр боллоо | |
| | | | | | Журмын дагуу эрүүл мэндийн тусламж | Хугацаа болоогүй | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Тэрбум, төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэ-лийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үйлчилгээ үзүүлэх байгууллагуудыг сонгон шалгаруулах ажлын төлөвлөгөө, хуваарийг боловсруулан, нэгжийн даргаар батлуулна. | | |
| | | | | | Журмын дагуу эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллагуудыг сонгон шалгаруулсан байна. | Хугацаа болоогүй | |
| | | | | | Нэгдсэн сонгон шалгаруулалтын үр дүнг даргын тушаалаар хуулийн хугацаанд албажуулна. | Хугацаа болоогүй | |
| 3.1.4 | *БСТ-3.1.2*<br>2025 оны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ, даатгуулагчдад эмийн үнийн | - | -Гэрээ дүгнүүлсэн байгууллагын тоо<br>-<br>Гэрээни | 2024 оны гэрээт 1507 эмийн сангийг гэрээг дүгнэж, хэрэгжилтийг 100 хувь хангаж ажилласан. | Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын гэрээний хэрэгжилтийг дүгнэх ажлын төлөвлөгөө, хуваарийг | Хугацаа болоогүй | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Тэрбум, төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэ-лийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөнгөлөлт үзүүлэх гэрээг дүгнэх ажлыг зохион байгуулна. | | й хэрэгжилтийн хувь | | боловсруулж, нэгжийн даргаар батлуулна. | | |
| | | | | | Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын гэрээг дүгнэж, холбогдох арга хэмжээг авч ажилласан байна. | Хугацаа болоогүй | |
| Зорилт 3.2.Даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарт холбогдох стандарт, эмнэлзүйн удирдамж, журмын дагуу хяналт тавьж, тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулна. | | | | | | | |
| 3.2.2 | *БСТ-3.2.3* Нэхэмжлэлийн хяналтын үр дүн, даатгуулагчийн гомдол, саналд хийсэн дүн шинжилгээний үр дүнд үндэслэж гэрээлэгч байгууллагад газар дээрх хяналт хийнэ. | - | Газар дээрх хяналт хийсэн гэрээт эрүүл мэндийн байгууллагын тоо | 2024 онд 90 лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага, 18 анхан шатны эрүүл мэндийн байгууллага, 7 эмийн сан нийт 115 эрүүл мэндийн байгууллагад газар дээрх хяналт шалгалтыг хийсэн. | Газар дээрх төлөвлөгөөт хяналтын хуваарийг боловсруулж, нэгжийн даргаар батлуулна. | ЭМДЕГ-ын даргын 2022 оын Журамж батлах тухйа А/60 дугаар тушаалын 6 дугаар зүйлд заасны дагуу гэрээний хэрэгжилти хангалтгүй буюу 70-75%-иас доош үнэлгээ авсан эрүүл мэндийн байгууллагуудад газар дээрх хяналт шалгалт хийхээр төлөвлөгөөг нэгжийн даргаар батлуулсан. | 100% |
| | | | | | Төлөвлөгөөт хяналт шалгалтыг хуваарийн дагуу болон төлөвлөгөөт бус газар дээрх хяналт шалгалтыг тухай бүрт хийж, зөрчил дутагдлыг арилгасан байна. | Газар дээрх төлөвлөгөөт бус хяналт хийх зорилгоор Нэхэмжлэлийн хяналтын тайланд хийсэн дүн шинжилгээгээр тухай ЭМБ нь нэхэмжлэлийн хугацаанд ирүүлсэн нэхэмжлэлийнх нь амжилтын хувь 70 ба түүнээс доош хангагдаагүй байдал сар бүр давтагдсан, нэхэмжлэлийн хугацаанд 3 ба түүнээс дээш тооны хуурамч нэхэмжлэл, код ахиулсан, завших оролдлогууд илэрсэн, эдгээр нь зөрчлийн санд бүртгэгдсэн эрүүл мэндийн байгууллагуудын жагсаалтыг авахаар Тусламж, үйлчилгээ, чанар, төлбөрийн хяналтын газарт 2025 оны 05 | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Тэрбум, төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэ-лийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дугаар сарын 14-ний өдрийн дотоод албан бичиг хүргүүлсэн.<br><br>**Төлөвлөгөөт бус хяналт шалгалтын тухайд-19:**<br><br>-Гэрээний үүргийн хэрэгжилтэд нийт **4** удаагийн удирдамж боловсруулж, **12** эрүүл мэндийн байгууллагад газар дээрх хяналт, шалгалтыг хийж, Уламжлалт анагаах ухааны Элэг судлалын төвд гэрээ түдгэлзүүлэх мэдэгдэл хүргүүлсэн бөгөөд 2 эрүүл мэндийн байгууллагад Улсын байцаагчийн 1,728,000 төгрийн акт тавьж, ЭМД-ын санд төвлөрүүлсэн. Үүнд:<br><br><u>Улсын нэгдүгээр эмнэлэг:</u><br>Эрүүл мэндийн яамнаас иргэн Б.Жигдэнгийн гомдлыг шийдвэрлүүлэхээр 2025 оны 9/547 дугаартай албан бичгээр ирүүлсий дагуу Худалдан авалт, гэрээлэлтийн газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 10-00-07/05 дугаартай газар дээрх хяналт хийх удирдамжийг боловсруулж, Улсын нэгдсэн төв эмнэлэгт газар дээрх хяналт, шалгалт хийсэн. хууль бусаар авсан 1023000 (нэг сая хорин гурван мянга) төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын санд шилжүүлүүлэхээр шийдвэрлэж, Улсын байцаагчийн 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 10-00-07-021/02 дугаартай акт тавьж, шийдвэрлүүлсэн. | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Тэрбум, төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэ-лийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Энх-Ундарга хувийн эмнэлэг:<br>Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд иргүүлсэн иргэн Ц.Алтангэрэл гомдлыг шийдвэрлэхээр 2025 оны 01 сарын 14-д 10-00-07/13 дугаар удирдамжаар боловсруулж, Энх-Ундарга хувийн эмнэлэгт газар дээрх хяналт, шалгалт хийсэн. Газар дээрх хяналтаар холбогдох баримт бичгийг хуурамчаар үйлдэн иргүүлж нэхэмжилсэн 705,000 төгрөг (Долоон зуун таван мянган төгрөг)-ийг эрүүл мэндийн даатгалын санд оруулахаар шийдвэрлэж, Улсын байцаагчийн акт хүргүүлсэн.<br>- Диализийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй зарим эрүүл мэндийн байгууллагуудад газар дээрх хналт хийх тухай 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 10-00-07/08 дугаартай удирдамж, шалгуур үзүүлэлтийг боловсруулж, 9 эрүүл мэндийн байгууллагад газар дээрх хяналт үнэлгээг хийж, үр дүнг нэгтгэж байна.<br>-Иргэн Г.Амардэлгэрийн 11-11-т гаргасан гомдлын мөрөөр Нийслэлийн Мандалфарм эмийн санд газар дээрх хяналт хийж, хяналт шалгалтын үр дүнг иргэнд мэдэгдсэн.<br>**Оношийн хамааралтай бүлэг, тусламж, үйлчилгээний төрөл нэмүүлэх хүсэлтийн хүрээнд-6:**<br>Нийслэлийн Эрүүл мэндийн байгууллагуудаас гэрээнд тусгагдаагүй тусламж, үйлчилгээ, оношийн хамааралтай бүлгүүдээр тусламж, үйлчилгээ үзүүлэх | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Тэрбум, төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэ-лийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | чадамжаа үнэлүүлж, нэмэлт гэрээ байгуулах хүсэлтүүдийг шийдвэрлэхээр Лавлагаа шатлалын **1**, Нийслэлийн анхан шатны **5**, нийт **6** эрүүл мэндийн байгууллагад газар дээрх хяналт, үнэлгээ хийсэн. Үүнд:<br><br>-Нийт **5** анхан шатын эрүүл мэндийн байгууллагаас УСЭИҮОШ-ний 18-30 насны багц тусламж, үйлчилгээ, ЭМД-ын тухай хуулийн 9.1.9-д заасан тусламж, үйлчилгээг гэрээнд нэмүүлэхээр ирүүлсэн хүсэлтийн дагуу, Нийслэлийн Баянзүрх дүүргийн Номгонжаргалант, Амь-Ундрах, Энх тунх, Цэнан, Өрнөх Эрүүл жаргал ӨМТ-дэд газар дээрх хяналт хийсэн.<br>-Лавлагаа шатлалын Сонгинохайрхан Нэгдсэн эмнэлгээс ирүүлсэн хүсэлтийн дагуу хийсэн газар дээрх хяналтын үр дүнг үндэслэн 12ОХБ-ийн хүрээнд УБ-01/025-0318 дугаартай нэмэлт гэрээ байгуулсан. | |
| | | | | | Шаардалагатай тохиолдолд орон нутаг дахь Эрүүл мэндийн даатгалын хэлтэст газар дээрх хяналтын чиглэл хүргүүлж, үр дүнг нэгтгэнэ/тооцно. | Орон нутгийн Эрүүл мэндийн байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийг судалж, газар дээрх хяналт хийх чиглэлийг харьяа орон нутаг хариуцсан Эрүүл мэнийн даатгалын хэлтэст хүргүүлж, үр дүнг тооцсон-**9**<br>Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийг судалж, харьяа орон нутгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсүүдэд дотоод албан бичиг хүргүүлж, лавлагаа шатлалын **4** (Завхан аймгийн Нэгдсэн эмнэлэг, Хөвсгөл аймгийн | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Тэрбум, төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэ-лийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Нэгдсэн эмнэлэг, Дархан аймгийн Нэгдсэн эмнэлэг, Увс аймгийн Нэгдсэн эмнэлэг), анхан шатны **5** (Сэлэнгэ аймгийн Жавхлант, Орхонтуул, Зүүнбүрэн, Ерөө СЭМТ, Төв аймгийн Архуст СЭМТ) эрүүл мэндийн байгууллагад **9** удаагийн газар дээрх хяналтыг хийлгүүлсэн. Газар дээрх хяналтын үр дүнг үндэслэн Завхан аймгийн Нэгдсэн, Увс аймгийнНэгдсэн эмнэлгүүдтэй нэмэлт гэрээ байгуулж, Сэлэнгэ аймгийн Жавхлант, Орхонтуул, Зүүнбүрэн, Ерөө, Архуст СЭМТ-дэд шүдний тусламж, үйлчилгээний ОХБ-ийг нээлгүүлсэн. Харин Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэг, Дархан аймгийн Нэгдсэн эмнэлэгүүдтэй нэмэлт гэрээ байгуулахаар төлөвлөсөн. | |
| 3.2.4 | Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль тогтоомж, ЭМДҮЗ-ийн тогтоолтой нийцүүлэн “Газар дээр нь очиж хийх хяналт шалгалтын журам”-ыг шинэчлэн батлана. | - | Шинэчлэн батлагдсан журам | ЭМДЕГ-ын даргын 2022 оны А/60 дугаар тушаал хэрэгжсэн. | Журмыг шинэчлэн боловсруулж батлана хэрэгжүүлсэн байна. | Хугацаа болоогүй | |
| 3.2.5 | Гэрээт эрүүл мэндийн байгууллагад зөвлөн туслах | - | Зөвлөн туслах үйлчилгээ | 2024 онд 502 ЭМБ-д зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. | Зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн байна. | -Олон нийтэд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 04 дүгээр тогтоолын хүрээнд Лавлагаа шатлалын эмнэлгүүдтэй хийж буй гэрээний талаарх | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Тэрбум, төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэ-лийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээ үзүүлнэ. | | үзүүлсэн байгууллагын тоо | | | мэдээллийг Eagle, Малчин, UBS телевизүүдэд ярилцлага өгсөн.<br>-Лавлагаа шатлалын ЭМБ-уудтай хийх 2025 оны гэрээ, нэмэлт гэрээнд Засгийн газраас авч буй бодлого, чиглэлийн талаар, төсвийн хүртээмж, хуваарьлалтын талаар ЭМБ-уудад таниулах, чиглэл өгөх зорилготой уулзалтыг Нийслэлийн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад ЭМДЕГ-ын 702 тоот өрөөнд, Орон нутаг дахь Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудад цахимаар хийсэн.<br>-Гэрээ байгуулсан нийт анхаш шатны 555, Лавлагаа шатлалын 300 эрүүл мэндийн байгууллагуудад гэрээний үүргийн хэрэгжилт, сарын төсвийн хуваарь боловсруулах зэрэгт зөвлөн туслах үйлчилээг үзүүлж ажиллаа. | 100% |
| 3.2.6 | *БСТ-3.2.4*<br>Өвөрхангай аймаг дахь ЭМДХ, Багануур, Налайх дүүрэг дэх эрүүл мэндийн даатгалын хэлтсийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, зөвлөн тусална. | - | Хяналт шалгалт, хийсэн нэгжийн тоо | Хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээ хийгдээгүй. | Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн үйл ажиллагаанд бусад нэгжтэй хамтарсан хяналт шалгалт, үнэлгээ хийгдсэн байна. | Хугацаа болоогүй | |
| **Зорилго 4.** Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг төрийн захиргааны нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангана. | | | | | | | |
| Зорилт 4.1. Хүний нөөцийн менежментийг байгууллагын онцлог, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлж, суралцагч байгууллага болон хөгжинө. | | | | | | | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Тэрбум, төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэ-лийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.5 | Монгол хэлний тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 7.2 дахь хэсгийг дагаж мөрдөн, 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөн явуулна. | - | -Хос бичгээр хөтлөн гаргасан албан бичгийн тоо,<br>-Хэрэгжилтийн хувь | - | Албан хэрэг хөтлөлтийг үе шаттай хэрэгжүүлж, зохих бэлтгэл хангасны үндсэн дээр албан хэргээ кирил болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулна. | Хугацаа болоогүй | |
| 4.1.6 | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллана. | - | Хэрэгжилтийн хувь | - | Тус газарт хамаарах заалтын хэрэгжилтийг хангаж тайлагнасан байна. | Нийт мэргэжилтнүүд | |
| 4.1.9 | *БСТ-1.2.3*<br>Даатгуулагч-иргэн, гэрээт байгууллагуудаас сэтгэл ханамжийн судалгаа авч, үр дүнг тодорхойлж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлнэ . | - | -Судалгаанд хамрагдсан иргэн, байгууллагын тоо<br>-Үйл ажиллагаандаа авч хэрэгжүү | Давхардсан тоогоор гэрээт 150 ЭМБ-аас сэтгэл ханамжийн судалгаа авсан. | -Сэтгэл ханамжийн судалгаа авч, үр дүнг тооцон үйл ажиллагаандаа нэвтрүүлнэ.<br>-Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зохион байгуулдаг судалгаатай уялдуулсан байна. | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас авч байгаа QR бүхий сэтгэл ханамжийн судалгааг мэргэжилтэн бүр ширээ болон өрөөний үүдэнд байршуулан, гэрээний хэлцэл хийхээр ирсэн болон бусад асуудлаар хандсан эрүүл мэндийн байгууллагуудаар тогтмол бөглүүлэн ажиллаж байна. | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Тэрбум, төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэ-лийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | лсэн арга хэмжээ | | | | |
| 4.1.13 | Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт, албан бичгийг шуурхай шийдвэрлэнэ. | - | Шийдвэрлэлтийн хувь | -2024 онд 2329 албан бичиг, өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн.<br>-"Иргэд олон нийттэй харилцах" 11-11 төвд нийт 144 өргөдөл, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэсэн.<br>-Хэрэглэгчтэй харилцах төвийн 1800-1363 лавлах утсанд ирсэн 515 өргөдөл, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэсэн. | Өргөдөл, гомдол, санал, хүсэлт, албан бичгийг хүлээн авч, хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна. | Албан байгууллагаас албан бичиг хэрэг хөтлөлтийн Абле системээр хариутай 976, хариугүй 83, нийт 1059 албан бичиг ирсэн бөгөөд хариутай албан бичгийн 871-ийг шийдвэрлэж, шийдвэрлэлт 89.2%-тай байна.<br>Иргэд байгууллагаас ирүүлсэн өргөдөл гомдлын тухайд Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах төсөөв 47, 1800-13-63 дугаарын утсаар 9, Абле системээр 26, нийт 82 өргөдөл, гомдол ирсэн бөгөөд шийдвэрлэлт 79.8%-тай байна. Үүнд:<br>Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөс 2025.01.02-2024.05.22-ны өдрийг хүртэлх хугацаанд Худалдан авалт, гэрээлэлтийн газарт 47 өргөдөл, гомдол ирснээс 38 буюу 80.8 хувь нь шийдвэрлэгдэж, 9 буюу 19.2 хувь нь шийдвэрлэх шатанд байна. Өргөдөл, гомдлыг төрлөөр ангилвал гомдол 41 буюу 87.2 хувь, хүсэлт 4 буюу 8.6 хувь, санал 1 буюу 2.1 хувь, шүүмжлэл 1 буюу 2.1 хувьтай байна.<br>1800-1363 лавлах утсаар 2025.01.02-2024.05.22-ны өдрийг хүртэлх хугацаанд Худалдан авалт, гэрээлэлтийн газарт нийт 9 гомдол ирснээс 7 буюу 77.8 хувь нь шийдвэрлэгдэж, 2 буюу 22.2 хувь нь шийдвэрлэх шатанд байна. | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Тэрбум, төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэ-лийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | АВЛЕ системээр 26 иргэд, байгууллагаас өргөдөл, гомдол, санал хүсэлт ирүүлсний 21 буюу 80.6%-ийг шийдвэрлэж, хяналтанд 4 өргөдөл, гомдол байна.<br>Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын мөрөөр ажиллаж, 4 иргэнд нийт 5,214,650,000 төгрөгийн буцаан олголтыг холбогдох эрүүл мэндийн байгууллагаар олгуулж, гомдлыг барагдуулсан. Үүнд:<br>-Иргэн Д.Баянжаргалын гомдлын мөрөөр Өмнөговь аймгийн БОЭТ-тэй холбогдож хэвтэн эмчлүүлж байх үед нь иргэнээр авахуулсан эм тарианы мөнгө 1,341,650 төгрөгийг буцаан олгуулсан.<br>-Иргэн Д.Отгондэлгэрээс нэмэлт төлбөр авсан талаар ирүүлсэн гомдлын мөрөөр ажиллаж, Улсын нэгдүгээр төв эмнэлгээс 150,000 төгрөний төлбөрийг буцаан олгуулсан.<br>-Иргэн Б.Жигдэнгийн гомдлыг шийдвэрлүүлэхээр УНТЭ-аас 1,023,000 төгрөг төлүүлсэн.<br>-Иргэн З.Мөнхтуяагийн гомдлын мөрөөр ажиллаж тухайн иргэний хууль бусаар төлсөн 2,700,000 төлбөрийг Сондра эмнэлгээс буцаан төлүүлж гомдлыг барагдуулсан.<br>Лавлагаа шатлалын 1, эмийн сан 7, нийт 8 эрүүл мэндийн байгууллагаас гэрээнд заасан хугацаанд илгээгээгүй хоцроосон нэхэмжлэлийг хянуулахыг хүссэн өргөдлийг нотлох баримт, хууль, эрх зүйн асуудлын | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Тэрбум, төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэ-лийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүрээнд судлан хүндэтгэн үзэх шалтгаантай тогтоогдсон 4 эмийн сангийн нэхэмжлэлийг хянуулахаар шийдвэрлэж, 4 удаагийн дотоод албан бичгээр ТҮЧТХГ-т шилжүүлсэн. Хүндэтгэн үзэх шалтгаан тогтоогдоогүй "Дархан-Оточ" ХХК-ийн эмнэлэг, "Ивээхүй" ХХК, "Буянт асгат хайрхан" ХХК, "Франтра" ХХК-ийн эмийн сангуудад хариуг албан бичгээр хүргүүлсэн.<br>Нэхэмжилсэн үнийн дүнгээс дутуу санхүүжүүлсэн төлбөрийг авах талаар 3 эрүүл мэндийн байгууллагаас гомдол ирүүлсэн бөгөөд Алтан могой" эмийн сангийн 2023 оны 02-05 сарын даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлсэн гүйцэтгэлийн нэхэмжлэл болох нийт 6,950,901 төгрөгийг нотлох баримт болон хууль, эрх зүйн талаас нь судлан 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, олгохоор шийдвэрлэсэн. Харин "Монос Сүхбаатар" ХХК, "Монос Дундговь" ХХК-аас ирүүлсэн гомдолд дутуу санхүүжүүлсэн нөхцөл байдал тогтоогдоогүй тул хариуг албан бичгээр хүргүүлсэн. | |
| 4.1.14 | Байгууллагын мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангаж, хяналт тавин ажиллана. | - | Үнэлгээний хувь | Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд нийт 2757 гэрээг бүрэн байршуулсан байна | Байгууллагын мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангаж, хангалттай үнэлгээ авсан байна. | **Шилэн дансанд байршуулсан гэрээ-2383**<br>Анхан шатны эрүүл мэндийн байгууллагатай байгуулсан үндсэн 555, нэмэлт 4, нийт 559, Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагатай байгуулсан үндсэн 17, нэмэлт 283, тусламж, үйлчилгээний ОХБ нэмүүлсэн 3, томуугийн түр 3, хаяг байршил, оноосон нэр өөрчлөгдсөн 1, нийт 307, эмийн сантай байгуулсан үндсэн 1509, хаяг | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Тэрбум, төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэ-лийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байршил өөрчлөгдсөнтэй холбоотой хийсэн нэмэлт 8, нийт 1517 гэрээг шилэн дансанд хуулийн хугацаанд нь байршуулсан. | |
| 4.1.18 | Цахим гарын үсгийг байгууллагын үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлнэ. | - | Цахим гарын үсгээр албажсан албан бичгийн тоо | 2024 онд байгууллагын хэмжээнд цахим гарын үсгээр 1554 албан бичиг баталгаажуулсан. | Цаасан хэлбэрт байгаа мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлэх, илгээх, хүлээн авах, хадгалах үйл ажиллагаанд цахим гарын үсэг нэвтрүүлсэн байна. | Цахим гарын үсгийг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх ажлын хүрээнд: Гэрээт лавлагаа шатлалын 298 байгууллагад 2025 оны гэрээнд цахим гарын үсгийг нэвтрүүлэх гэж буй талаарх мэдээллийг албан бичгээр хүргүүлж, бэлтгэл ажлын хангаж, ажиллах талаар мэдэгдсэн бөгөөд 2025 оны Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээг цахимаар хийсэн.<br>Мөн албан хэрэг хөтлөлтийн able програмаар 298 албан бичгийг цахимаар төлөвлөн, холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллаа. | 100% |
| | | | | | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээг цахим гарын үсгээр баталгаажуулан, байгуулна. | Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагатай 2025 онд байгуулсан Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах нэмэлт гэрээг 283 байгууллагатай цахим хэлбэрээр тоон гарын үсгээр хийж, шилэн дансанд байршуулан ажиллаа. | |
| Зорилт 5.Эрүүл мэндийн сайдаас тусгайлан үүрэг болгосон арга хэмжээг бүрэн хэрэгжүүлнэ. | | | | | | | |
| 5.6 | Төвлөрөл сааруулах бодлогын хүрээнд гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын үндэсний багтай | - | Шийдвэрлэлтийн хувь Санхүүжилтийн | 3 ЭМБ-ын 11 албан бичигт хамаарах давхардсан тоогоор 73 гэрээлээгүй ОХБ-ийг цахим системд | Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын үндэсний багтай хамтран үзүүлсэн тусламж, үйлчилгээний | - Үндэсний багийн орон нутагт төвлөрөл сааруулах ажлын хүрээнд хийгдсэн мэс заслын тусламж, үйлчилгээний ОХБ-ийг Өмнөговь аймагийн БОЭТ-4 удаагийн дотоод албан бичгээр 58 ОХБ, Өвөрхангай аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд 3 удаагийн дотоод албан | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Тэрбум, төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэ-лийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хамтран үзүүлсэн тусламж үйлчилгээний хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэнэ. | | мөнгөн дүн | түр нээлгэн, тусламж, үйлчилгээний гүйцэтгэл ирүүлэх талаар хариу хүргүүлэн ажилласан. | хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэн, бүртгэлжүүлнэ. | бичгээр 15 ОХБ, Төв аймгийн Нэгдсэн эмнэлэгт 2 удаагийн дотоод албан бичгээр 7ОХБ, ОХБ Завхан аймгийн НЭ-1 удаагийн дотоод албан бичгээр 1 ОХБ, Увс аймгийн НЭ-т 1 удаагийн дотоод албан бичгээр 1 ОХБ, Орхон аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд 9 удаагийн дотоод албан бичгээр 22 охб, Дорнод аймгийн БОЭТ-д 2 удаагийн дотоод албан бичгээр 3 ОХБ, Баянхонгор аймагт 2 удаагийн дотоод албан бичгээр 17 ОХБ, нийт **8** аймагт, **22** удаагийн дотоод албан бичгээр **124** ОХБ-ийг цахим системд түр нээлгүүлж, тусламж, үйлчилгээ авсан иргэдийн нэхэмжлэлийг санхүүжүүлэх боломжоор хангасан.<br><br>- Яаралтай журмаар хийгдсэн мэс заслын тусламж, үйлчилгээний 9 ОХБ-ийг ЭМДҮЗ-ийн тогтоолд заасны дагуу 9 лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад (ЭНЭҮТ-2, Дорнод аймгийн Баян-Уул сумын ЭМТ, Налайх дүүргийн Эрүүл мэндийн төвд, Архангай аймгийн Нэгдсэн эмнэлэг-3, Орхон аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төв;-2, Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлэг) түр нээж, нэхэмжлэл илгээх боломжоор хангасан. | |
| 5.7 | Гэрээт лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагаас ирүүлсэн Эрүүл | - | Нэмэлт гэрээ байгуулсан ЭМБ-ын тоо | 2024 онд давхардсан тоогоор 57 ЭМБ-тай Эрүүл мэндийн тусламж, | Бүс нутгийн хэмжээнд хүртээмж хангагдаагүй нэн шаардлагатай, | Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудаас гэрээнд тусгагдаагүй оношийн хамааралтай бүлгүүдээр тусламж, үйлчилгээ үзүүлэх чадамжаа үнэлүүлж, нэмэлт гэрээ байгуулах хүсэлтүүдийг | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Тэрбум, төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэ-лийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах нэмэлт гэрээ байгуулах хүсэлтийг судалж, тусламж үйлчилгээний эрэлт хэрэгцээн дээр тулгуурлаж шийдвэрлэнэ. | | | үйлчилгээ худалдан авах нэмэлт гэрээ байгуулсан. | төвлөрөл сааруулах тусламж, үйлчилгээний жагсаалтыг Бодлого төлөвлөтийн газраас авна. | шийдвэрлэхээр Улсын хэмжээнд хүртээмж хангагдаагүй, нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалтыг авахаар Бодлого төлөвлөлтийн газарт 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 07/182 дугаартай албан бичиг хүргүүлж, хариуг 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 06/216 дугаартай дотоод албан бичгээр авсан.<br>- Бүс нутгийн хэмжээнд хүртээмж хангагдаагүй төвлөрөл сааруулах, гадагшаа явах усргалыг бууруулах тусламж, үйлчилгээний жагсаалтыг Бодлого төлөвлөтийн газраас авахаар 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 07/421 дугаартай дотоод албан бичгийг хүргүүлсэн боловч хариу ирүүлээгүй. | 100% |
| | | | | | Бүс нутгийн хэмжээнд хүртээмж хангагдаагүй нэн шаардлагатай, төвлөрөл сааруулах тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлэгт хамаарах шалгуур хангаж буй эсэхийг хүсэлт ирүүлсэн эрүүл | Бүс нутгийн хэмжээнд хүртээмж хангагдаагүй, нэн шаардлагатай тусламж, үйлчилгээгээр хүсэлт ирүүлсэн нийт анхан шатны **10**, лавлагаа шатлалын **5**, нийт **15** эрүүл мэндийн байгууллагад газар дээрх хяналт, үнэлгээ хийж, үр дүнг тооцсон. Үүнд:<br><br>- Нийслэлийн анхан шатын **5** эрүүл мэндийн байгууллагаас УСЭИҮОШ-ний тусламж, ЭМД-ын тухай хуулийн 9.1.9-д заасан тусламж, үйлчилгээг гэрээнд нэмүүлэхээр ирүүлсэн хүсэлтийн дагуу Нийслэлийн Баянзүрх дүүргийн Номгонжаргалант, Амь-Ундрах, Энх тунх, Цэнан, Өрнөх Эрүүл жаргал ӨМТ-дэд газар дээрх хяналт хийсэн. | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Тэрбум, төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэ-лийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мэндийн байгууллагад газар дээрх хяналт, үнэлгээ хийнэ. /орон нутгийн даатгалын хэлтэст чиглэл хүргүүлж, үр дүнг тооцно/ | - Лавлагаа шатлалын Сонгинохайрхан Нэгдсэн эмнлэгээс ирүүлсэн хүсэлтийн дагуу хийсэн газар дээрх хяналтын үр дүнг үндэслэн 12 ОХБ-ийн хүрээнд УБ-01/025-0318 дугаартай нэмэлт гэрээ байгуулсан.<br><br>-Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийг судалж, харьяа орон нутгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсүүдэд дотоод албан бичиг хүргүүлж, лавлагаа шатлалын **4** (Завхан аймгийн Нэгдсэн эмнэлэг, Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэг, Дархан аймгийн Нэгдсэн эмнэлэг, Увс аймгийн Нэгдсэн эмнэлэг), анхан шатны **5** (Сэлэнгэ аймгийн Жавхлант, Орхонтуул, Зүүнбүрэн, Ерөө СЭМТ, Төв аймгийн Архуст СЭМТ) эрүүл мэндийн байгууллагад **9** удаагийн газар дээрх хяналтыг хийлгүүлсэн.<br><br>**Хийхээр төлөвлөсөн газар дээрх хяналт:**<br><br>-Орхон аймгийн Эрдэнэт медикал эмнэлэгт газар дээрх хяналт хийх удирдамж боловсруулж нэгжийн даргад танилцуулсан байна.<br>-Говьсүмбэр аймгийн Энхбилэг эмнэлгээс ирүүлсэн ОХБ нэмж гэрээлэхээр ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэхээр Говьсүмбэр аймаг дахь Эрүүл мэндийн даатгалын хэлтэст аймгийн хэмжээнд 612044341, 622041971, 612043021, 612062321 оношийн хамааралтай бүлгийн хүрээнд хэрэгцээ | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Тэрбум, төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэ-лийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шаардалага байгаа эсэх, хүртээмж хангагдсан эсэх талаарх судалгааг Аймгийн Эрүүл мэндийн газраас тодруулж, хариу ирүүлэх талаар ДАБ бичиг хүргүүлсэн бөгөөд ирүүлсэн хариуг үндэслэн газар дээрх хяналт хийхээр төлөвлөсөн.<br>-УГТЭ, Цэргийн төв, ХСҮТ, Бриллиант, УХТЭ, Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төв, Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв, ТТАХ-ын Нэгдсэн эмнэлэгүүдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу дээр газар дээрх хяналт, хийх удирдамж, хуваарийг боловсруулж, нэгжийн даргаар батлуулсан бөгөөд эрүүл мэндийн байгууллагуудад албан бичгээр мэдэгдсэн. | |
| | | | | | Төвлөрөл сааруулах бодлого, бүс нутгийн хэмжээнд хүртээмж хангагдаагүй тусламж, үйлчилгээний жагсаалтад багтсан оношийн хамааралтай бүлгээр тусламж, үйлчилгээ үзүүлэх шаардлага хангасан ЭМБ-тай батлагдсан төсвийн хүрээнд нэмэлт гэрээг | Бүс нутгийн хэмжээнд хүртээмж хангагдаагүй, нэн шаардлагатай тусламж, үйлчилгээгээр хүсэлт ирүүлсэн анхан шатны **2**, лавлагаа шатлалын **3**, нийт **5** эрүүл мэндийн байгууллагуудтай газар дээрх хяналт үнэлгээний үр дүнг үндэслэж, төсвийн хүрээнд нэмэлт гэрээг байгуулан ажиллаа. Үүнд:<br><br>-Хүсэлт ирүүлсэн **2** анхан шатын эрүүл мэндийн байгууллагуудад хийсэн газар дээрх хяналтын үр дүнг үндэслэн ЭМД-ын тухай хуулийн 9.1.9-д заасан тусламж, үйлчилгээгээр Нийслэлийн Номгонжаргалант ӨМТ, УСЭИҮОШ-ний 18-30 насны багц тусламж, үйлчилгээгээр Өрнөх Эрүүл жаргал ӨЭМТ-тэй нэмэлт гэрээ байгуулж, шалгуур хангаагүй Энхтунх ӨЭМТ- | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Тэрбум, төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэ-лийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгуулж, цахим системд бүртгэх, холбогдох арга хэмжээг авч ажиллана. | д гэрээ байгуулах боломжгүй талаарх мэдэгдлийг хүргүүлсэн.<br>-Харьяа орон нутгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсүүдээр хийлгэсэн газар дээрх хяналтын үр дүнг үндэслэж, лавлагаа шатлалын Увс аймгийн Нэгдсэн эмнэлэг, Завхан аймгийн Нэгдсэн эмнэлэг, Нийслэлийн Сонгинохайрхан Нэгдсэн эмнэлэгтэй нэмэлт гэрээг байгуулсан.<br>**Төлөвлөгдсөн нэмэлт гэрээ:**<br>- Лавлагаа шатлалын Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэг, Дархан аймгийн Нэгдсэн эмнэлэгтэй, анхан шатны Нийслэлийн Баянзүрх дүүргийн Амь-Ундрах, Цэнан ӨМТ-тэй нэмэлт гэрээ байгуулахаар төлөвлөсөн. | |

ТАНИЛЦСАН:

ХУДАЛДАН АВАЛТ, ГЭРЭЭЛЭЛТИЙН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ: Ж.НАРАНГЭРЭЛ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ХУДАЛДАН АВАЛТ, ГЭРЭЭЛЭЛТИЙН
ГАЗРЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН: Ч.ОРГИЛТУЯА

-ooOoo-